

# FINANCIAL REGULATORY COMMISSION



## Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам

- Хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, хүрэх үр дүн

Д.Ганбаяр

2015 оны 3-р сарын 15

- Улс орны хөгжил -> Эдийн засгийн хөгжил -> Компанийн хөгжил -> Хувь хүний хөгжил
- Засаглалын зарчим: Хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, түншлэгчид, үйлчлүүлэгчиддээ
  - нээлттэй,
  - ил тод,
  - шударга хандаж

Компанийн дээд удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл нь:

- хяналт
- Хариуцлага
- алсын харааг хэр зөв тодорхойлж,
- зөвлөж ажиллаж

# Компанийн засаглалын талаархи ойлголт

## ‘Үнэт зүйлс’:


- Ил тод, нээлттэй, хяналттай, хариуцлагатай, эрх тэгш

## ‘Бодлого’:

- Засаглал сайн байж хөрөнгө оруулалт татах, хувьцаа гаргах
- Бодлого шийдвэр, Бизнес стратеги


## ‘Тогтолцоо’:

- ТУЗ, дэд хороодын үйл ажиллагаа хэвшил болсон байх
- Засаглалын зарчим хэрэгжих тогтсон механизм бүрдүүлэх



# Санхүүгийн салбарын засаглалын тогтолцоо

Монголын санхүүгийн зах зээлд салбарын эзлэх хувь хэмжээ  
/2015 оны хагас жилийн эцсийн байдлаар, төгрөг/



- Банкны зах зээл - 21 их наяд / 90.7%
- Үнэт цаасны зах зээл-1,4 их наяд / 6%
- Банк бус санхүүгийн зах зээл - 508 тэрбум / 2.2%
- Даатгалын зах зээл - 152 тэрбум / 0.7%
- Хадгаламж зээлийн хоршоо - 80 тэрбум

# Монголын санхүүгийн зах зээлд салбарын ЭЗЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ

/ 2015 оны хагас жилийн байдлаар, Тэрбум төгрөг /

Салбар	Хөрөнгө	Өр төлбөр	Эзэмшигчийн өмч	Өр төлбөр/ Нийт хөрөнгө	Борлуулалт	Цэвэр ашиг	Цэвэр өгөөж
<b>ТОП-20 ХК</b>	1,108.9	612.1	496.8	55.20%	297.1	9.0	3.04%
<b>Арилжаалагдаж буй ХК – 169</b>	2,606.7	1,075.5	1,531.2	41.26%	548.4	(4.5)	-0.83%
<b>Нийт ТӨК-77</b>	6,267.6	2,881.3	3,386.3	45.97%	3,256.1	110.5	3.39%
<b>Арилжааны банк – 13</b>	21,598.6	19,380.1	2,218.4	89.73%	917.2	302.9	33.03%
<b>Итгэлцэл ББСБ-30</b>	231.6	112.4	119.2	48.54%	65.4	19.8	30.29%
<b>Хадгаламж зээл – 30 (300 сая дээш хөрөнгөтэй)</b>	72.6	57.7	7.5	79.38%	8.6	1.2	14.46%
<b>Даатгал – 18</b>	171.1	82.9	88.1	48.48%	107.6	3.1	2.92%

# Монголын ТОП-20 ХК-ийн санхүүгийн үзүүлэлт


/2015 оны хагас жилийн байдлаар, мянган төгрөг/

№	НЭРИЙН КС	САЛБАР	КОД	ХУВЬЦААТ КОМПАНИЙН НЭР	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөгөөр/				ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ		ХАРЬЦАА
					Нийт хөрөнгө	Өр төлбөр	Эзэмшигчдийн өмч	Өр төлбөр/ Нийт хөрөнгө	Цэвэр борлуулалт	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	Цэвэр өгөөж ↕
1	HRM	Е	528	Гермес центр	8,479,200.2	220,366.1	8,258,834.1	2.6%	743,764.9	389,279.6	48.67%
2	BNG	Е	13	Баянгол Зочид Буудал	37,488,664.7	4,733,181.5	32,755,483.2	12.6%	2,222,826.4	841,752.6	33.05%
3	GOV	В	354	Говь	112,943,122.6	59,068,250.1	53,874,872.5	52.3%	22,516,452.6	2,423,571.2	10.32%
4	TCK	В	22	Талх чихэр	37,197,431.9	13,613,544.1	23,583,887.8	36.6%	17,770,632.0	1,492,079.7	8.37%
5	BDS	Е	522	Бидисек	13,708,656.0	163,053.8	13,545,602.2	1.2%	910,555.8	82,523.9	5.91%
6	APU	В	90	АПУ	325,226,880.5	187,274,203.9	137,952,676.6	57.6%	101,756,821.4	5,851,511.7	5.73%
7	UID	Е	484	Улсын Их Дэлгүүр	9,914,671.2	10,720,657.5	- 805,986.3	108.1%	2,700,000.0	104,768.1	3.88%
8	BAN	А	396	Багануур	98,851,785.7	91,815,115.7	7,036,670.0	92.9%	48,587,149.9	1,443,960.1	2.90%
9	MMX	В	208	Мах импэкс	14,759,983.4	12,350,584.1	2,409,399.3	83.7%	13,968,495.9	252,008.5	1.78%
10	NEH	В	71	Дархан нэхий	47,638,434.3	15,065,023.4	32,573,410.9	31.6%	6,561,135.3	95,528.2	1.37%
11	TTL	А	458	Таван толгой	64,628,589.6	23,610,185.4	41,018,404.2	36.5%	12,480,343.9	40,825.2	0.32%
12	SHG	А	309	Шарын гол	70,266,045.4	40,851,057.3	29,414,988.1	58.1%	12,385,018.5	- 12,608.3	-0.10%
13	MIE	Е	379	Материал-Импекс	25,113,315.0	16,058,556.8	9,054,758.2	63.9%	17,619,188.1	- 32,706.4	-0.18%
14	MCH	Е	209	Монголын цахилгаан холбоо	40,883,786.6	9,013,220.5	31,870,566.1	22.0%	9,896,764.1	- 101,876.0	-0.99%
15	BUK	Д	195	Улаанбаатар Бүк	40,441,063.4	11,813,947.7	28,627,115.7	29.2%	4,453,727.9	- 191,410.6	-4.20%
16	MDR	Д	524	MDR	16,260,454.4	115,771.1	16,144,683.3	0.7%	429,364.6	- 19,275.1	-4.48%
17	SHV	А	460	Шивээ Овоо	93,986,400.2	86,315,596.0	7,670,804.2	91.8%	17,921,449.8	- 2,132,861.1	-11.85%
18	JTB	Е	521	Женко тур бюро	9,729,521.8	1,721,047.9	8,008,473.9	17.7%	1,336,152.3	- 248,746.6	-18.61%
19	RMC	В	530	Ремикон	21,328,368.4	14,001,297.7	7,327,070.7	65.6%	2,302,716.4	- 970,949.9	-41.93%
20	HGN	А	532	Хөх ган	20,125,510.5	13,605,628.4	6,519,882.1	67.6%	521,371.2	- 269,431.7	-51.68%
<b>НИИТ</b>					<b>1,108,971,885.8</b>	<b>612,130,289.0</b>	<b>496,841,596.8</b>		<b>297,083,931.0</b>	<b>9,037,943.1</b>	

Эх сурвалж: Монголын хөрөнгийн биржийн сайтаас (татварын байгууллагаас авсан) авч тооцоолол хийв.


# Олон улсын үнэт цаасны зах зээлийн харьцуулалт

## Азийн орнуудын Хувьцааны хөрвөх чадварын харьцуулалт




# Олон улсын үнэт цаасны зах зээлийн харьцуулалт

## ДНБ-д эзлэх ХК-иудын Зах зээлийн үнэлгээ /хувь/





## МХБ-д бүртгэлтэй ХК-иудын хувьцаа эзэмшигчдийн тоо, эзлэх хувь



- Идэвхигүй хувьцаа эзэмшигчид
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөх байдал түгээмэл байсаар байна.
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх эрх
- Ногдол ашиг хувиарлах байдал
- Мэдээллийг олон нийтэд ил тод болгох асуудал

# Үнэт цаас гаргагч – хөрөнгө оруулагч

- **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОСГОХ - ИДЭВХИТЭЙ АРИЛЖАА**
  - **Худалдан авагч – Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид**
    - Хөрөнгийн зах зээл гэж юу вэ? Яаж оролцох талаархи ойлголт
    - Худалдаж авах бүтээгдэхүүнээ таних? Мэдээлэл, ил од байдал
    - Итгэл төрүүлэхүйц зах зээл мөн үү? Эрх ашгийг нь хамгаалах эсэх
    - Хөрөнгийн зах зээл-Хувьцаа, Бонд <-> Мөнгөний зах зээл-Хадгаламж
    - Хөрөнгө оруулагчдыг татах, оролцогч талууд шударга эсэх? Хөрөнгө оруулагчид
  - **Борлуулагчид=МХБ дээр хувьцаа, бонд гаргах**
    - Үнэт цаас гаргах сонирхол, идэвхи оролцоо -> Asset to Debt ratio >47% (loan from bank with interest of 18%)
    - Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах - засаглал
    - Үнэт цаас гаргах хөшүүрэг, хөнгөлөлт – давуу тал
    - Хувьцаат компани байхын ашиг тус, нэр хүнд – өрсөлдөх чадвар

- **Хөрөнгө оруулагчид** ←--→ **Өмчийн эзэд**  
**эрх ашиг**  
**ашиг сонирхол**

# Засаглалын үнэлгээний журмын үндэслэл

- Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 69 тоот тогтоолоор **“Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”**-ийг баталсан.
- Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын 2 дахь заалтад **“Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах, хувьцаат компанийн засаглалд хөндлөнгийн үнэлгээ, хяналт, шалгалт хийх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах механизмыг бий болгох”**,
- 4 дэх заалтад **“Компанийн засаглалын түвшний үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх тогтолцоо бий болгох”**
- Хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэнд **“Компанийн засаглалын үнэлгээний индексийг Хөрөнгийн биржийн жагсаалтад орсон хувьцаат компани болон төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн холбогдох байгууллага мөрддөг болсон байх”** гэж тодорхойлсон
- Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 444 тоот тогтоолоор **Компанийн засаглалын үндэсний зөвлөлийг** цаашид санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, компанид засаглалын үнэлгээ хийж олон нийтэд мэдээлэх, компанийн ил тод байдлыг хангах ажлыг төр, хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр мэргэжлийн институтын түвшинд хариуцаж ажиллахыг даалгасан

# Засаглалын үнэлгээний журмын үндэслэл

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.10-т **“Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх”** гэж тусгасан
- “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 2.3.2.6-д үнэт цаас гаргагч нь Хорооноос баталсан **“Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайланг жилийн үйл ажиллагааны тайландаа тусгаж өгөхөөр** заасан
- Монгол хөрөнгийн биржийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 14 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 11.1.6-д хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч нь **“дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх”**, 12.1.5-д хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч нь **“дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах”** гэж тус тус заасан байдаг.
- Хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд Хөрөнгийн биржийн I, II ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниуд болон олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн, нийтийн ашиг сонирхолын төлөө үйл ажиллагаа явуулдаг **компаниудын засаглалыг сайжруулах**, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт үнэн зөв **бодит мэдээллийг цаг тухайд хүргэх, хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгох** шаардлагад тулгуурлан уг журмын төслийг боловсруулж байна.

# Компанийн засаглалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

/ Засгийн газраас 2011 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 69 тоот тогтоолоор /

## Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

1. Санхүүгийн зохицуулах хороо,
2. Монгол банк,
3. Төрийн өмчийн хороо,
4. Сангийн яам,
5. Аж үйлдвэрийн яам
6. Монголын хөрөнгийн бирж,
7. МҮХАҮТ,
8. Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо,
9. Компанийн засаглалын хөгжлийн төв

**1-р үе шат:** Хууль,  
дүрэм журмаар  
хэрэгжүүлэх  
шаардлагыг бий болгох  
/2011-2012/

**2-р үе шат:**  
Компаниуд өөрсдөө  
ойлгож сайн дураар авч  
хэрэгжүүлэх  
/2013-2014/

**3-р үе шат:** Засаглалын  
үнэлгээ хийх, ил тод  
мэдээллэж бизнесийн үйл  
ажиллагаанд нөлөөлөх  
/2015-2016/

# Журмын нийтлэг үндэслэл

- Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангуулах,
- Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг дагаж мөрдүүлэх,
- Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх, засаглалын түвшинг сайжруулах зорилгоор
  - компанид засаглалын хөндлөнгийн үнэлгээ хийх, түвшинг тогтоох,
  - түүнийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнах, компанийн сайн засаглалын тогтолцоог бий болгоход энэхүү журмыг удирдлага болгоно.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.10-т заасан “Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулахад чиглэн ажиллана
- Хөрөнгийн биржийн I ба II ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниуд нь
  - Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржийн холбогдох дүрэм, журмын хүрээнд засаглалын үнэлгээг зөвлөл, түүний ажлын албаар үнэлүүлж, түвшинг тогтоолгон хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.
- Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн,
- Нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг компаниудын
  - засаглалын үнэлгээг тухайн компанийн удирдлага /Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага/, хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр хийж гүйцэтгэж болно.

# Компанид засаглалын үнэлгээ хийх эрх бүхий этгээд

- Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:
  - засаглалын үнэлгээний нэгдсэн аргачлалыг боловсруулж Хороогоор батлуулна;
  - засаглалын үнэлгээний нэгдсэн аргачлалын дагуу хараат бус, мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ;
  - засаглалын үнэлгээний тайланг компанийн удирдлагад танилцуулна;
  - тайланд тусгагдсан асуудлаар засаглалыг сайжруулахад зөвлөмж өгч болно;
  - засаглалын үнэлгээний тайланг жилийн үйл ажиллагааны тайланд тусгуулж, шаардлагатай бол хувьцаа эзэмшигчдэд мэдээлж болно;
  - засаглалын үнэлгээг компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн үнэлгээчээр гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно;
  - энэ журмын 1 дүгээр хавсралтанд тусгасан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох аргачлал”-ын дагуу засаглалын үнэлгээг хийнэ.

# Компанид засаглалын үнэлгээ хийх эрх бүхий этгээд

- Хөрөнгийн биржийн I ба II ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниуд засаглалын үнэлгээг 2 жил тутамд хийлгэж хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх үүрэгтэй.
- Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаагаа явуулдаг аливаа компаниуд засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болно. Үүнд:
  - төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани;
  - арилжааны банк;
  - даатгалын компани;
  - хадгаламж зээлийн хоршоо;
  - аудитын компани;
  - итгэлцлийн үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллага;
  - бусад аж ахуйн нэгжүүд.
- Компани нь дараах тохиолдолд засаглалын үнэлгээг хийлгэнэ. Үүнд:
  - олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн бол уг шийдвэрийг үндэслэн компанийн удирдлагын хүсэлтээр;
  - хувьцаат компани Хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн ангилалд өөрчлөлт оруулах шаардлагын дагуу;
  - компанид засаглалын түвшинд үүссэн хямралаас шалтгаалан хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөж байна гэж үзсэн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн эсвэл компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр;



- Засаглалын үнэлгээний дүнгээс хамаарч дараах байдлаар засаглалын түвшинг тогтооно. Үүнд:
  - засаглалын үнэлгээ **75 оноогоос дээш** байвал **сайн засаглалтай** буюу компанийн удирдлагын үйл ажиллагаа хэвийн;
  - засаглалын үнэлгээ **50-74 оноо** байвал **дунд засаглалтай** буюу компанийн удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсч болзошгүй;
  - засаглалын үнэлгээ **25-49 оноо** байвал **хангалтгүй засаглалтай** буюу компанид хяналт шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;
  - засаглалын үнэлгээ **24 оноогоос доош** байвал **муу засаглалтай** компани буюу компанийн удирдлагын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай.

- Хувьцаат компани нь засаглалын үнэлгээний тайланг жилийн үйл ажиллагааны тайландаа тусгаж хувьцаа эзэмшигчдээ мэдээлнэ.
- Хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн ангилалд өөрчлөлт оруулахаар засаглалын үнэлгээ хийгдсэн бол зөвлөл нь уг үнэлгээний тайланг Хөрөнгийн биржид хүргүүлнэ.
- Компани нь засаглалын үнэлгээний түвшинг Хөрөнгийн биржийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэж болно.
- Засаглалын үнэлгээний тайланг компанийн зөвшөөрлөөр Хороо болон зөвлөлийн цахим хуудсаар нийтэд мэдээлж болно.

- **Компанид засаглалын үнэлгээг хийж, түвшин тогтоохын тулд тухайн**
  - компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх хамгаалагдсан байдал,
  - төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үр өгөөж,
  - гүйцэтгэх удирдлагын менежментийн чадвар,
  - компанийн нээлттэй байдал болон нийгмийн хариуцлага,
  - компанийн оролцогч талуудтай харилцах харилцаа зэргийг үнэлнэ.
- **Засаглалын үнэлгээг хийхдээ**
  - Компанийн тухай хууль,
  - Компанийн засаглалын кодексийг гол шалгуур болгох
  - зохицуулалттай этгээдийн эрх зүйн хэм хэмжээг шалгуур болгоно.

## Хувьцаа эзэмшигчдийн эрх

- хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүд хангагдсан эсэх,
- хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуулийн дагуу явагддаг эсэх,
- жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийн хамгаалалж байгаа зэрэг асуудлууд

## Нээлттэй ил тод байдал

- компани жилийн үйл ажиллагааны тайлан
- цахим хуудастай эсэх, шаардлагатай мэдээлэл орсон эсэх
- жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудас нь Хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын хүрээнд мэдээллийг бүрэн агуулдаг эсэх,
- компани хөрөнгө оруулагч, харилцагч байгууллага зэрэг оролцогч талуудад нээлттэй ил тод байдлыг хангасан байдал, компани мэдээллийн журмаа мөрдөн ажиллаж байгаа эсэх

## **ТУЗ -ын хүлээх үүрэг хариуцлага**

- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа нь хуульд нийцэж байгаа эсэх,
- ТУЗ-ийн дэд хороодын үйл ажиллагаа,
- ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалт,
- ТУЗ нь үйл ажиллагааны журмаа мөрдөн ажиллаж байгаа эсэх

## **Гүйцэтгэх удирдлага**

- Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэх
- Гүйцэтгэх удирдлагын ёс зүйн дүрмээ мөрдөж байгаа эсэх

## **Оролцогч талууд**

- Компани өөрийн харилцагчид болох бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, ажиллагсад, харилцагч банк, өрсөлдөгч, хөрөнгө оруулагч, төрийн байгууллага зэрэг этгээдүүтэй харилцах бодлого журамтай эсэх,
- Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх байдал, нийгмийн хариуцлага хэрэгжүүлдэг эсэх зэрэг оролцогч талуудтай холбоотой харилцааг үнэлнэ.

## **Баримт бичгийн шалгалт:**

- Засаглалын үнэлгээ хийлгэж буй компанийн дотоодод мөрдөгддөг засаглалтай холбоотой эрх зүйн хэм хэмжээний актууд нь агуулгаараа Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексд нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

## **Хэрэгжилийг шалгах:**

- Баримт бичигт тусгагдсан хэм хэмжээнүүд бодит байдал дээр компанийн үйл ажиллагаанд хэрэгждэг эсэхийг шалгана. Мөн компани дотоод дүрэм журамдаа тусгасан боловч үйл ажиллагаандаа хэвшүүлсэн эсэхийг давхар шалгана.

## **Үнэлгээ ба тайлагнал:**

- Засаглалын үнэлгээний 1 ба 2 дугаар шатанд нягталсан тухай компанийн нотлох баримт бичигт үндэслэн асуулга тус бүрт зохих үнэлгээний оноог өгч, нэгдсэн засаглалын үнэлгээний тайланг гаргана.

- “4” оноо буюу бүрэн хэрэгжүүлдэг
- “3” оноо буюу хэрэгжүүлдэг
- “2” оноо буюу хагас хэрэгжүүлдэг
- “1” оноо буюу зарим хэсгийг хэрэгжүүлдэг
- “0” оноо буюу хэрэгжүүлдэггүй

# Үнэт цаасны зах зээлийн тогтолцоо

## Зохицуулалт

FRC

Хөрөнгө оруулалт татах  
ЭРЭЛТ

Хөрөнгө оруулах сонирхол  
НИЙЛҮҮЛЭЛТ

Аж ахуйн  
нэгж - ХК

Арилжаа хийх  
Хөрөнгийн  
бирж


Хөрөнгө оруулагчид  
- Дотоод  
- Гадаад  
- Мэргэжлийн

Хөрөнгө  
босгож өгөх  
Underwriter

**Үндэсний Зөвлөл**

- Үнэлгээ, зэрэглэл
- Тайлагнал, ил тод
- Судалгаа хийх
- Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах,

Зуучлагч  
Брокер





# Цаашдын үйл ажиллагаа

- **Үнэлгээ**

- Нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн, нийтийн ашиг сонирхолын төлөө ажилладаг компаниудын засаглалын үнэлгээг тогтмол хийх
- Үнэлгээнд тулгуурлан компаниудын ангилан, зэрэглэл тогтоох
- Салбараар нь компанийн засаглалд үнэлгээ өгч түвшинг тогтоох
- Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрх хангагдаж байгаа эсэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл явцад үнэлгээ өгөх

- **Мэдээллийг түгээх**

- Хоёр жил тутамд салбарын засаглалын нэгдсэн тайланг гаргаж түгээх
- Компанийн засаглалын портал сайтаар тогтмол мэдээллэх
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр

- **Судалгаа**

- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулалын тогтолцоо, хувь хэмжээг гүйцэтгэлтэй нь уялдаж байгаа эсэх
- Эрх бүхий албан тушаалтны томилгоо нь холбогдох хууль, журмын хүрээнд хэрэгжиж байгаа эсэх
- ТУЗ, түүний дэд хороод нь хууль, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж чадаж байгаа эсэх
- Компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо хэрэгжиж байгаа эсэх

# Цаашдын үйл ажиллагаа

- **Хэлэлцүүлэг**
  - Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтын хөтөлбөр, түвшинг сайжруулах
  - Сургагч багшийг бэлтгэх, холбогдох гарын авлага, шалгалтын товхимол бэлтгэх
  - ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчидад зориулсан богино сургалтын хөтөлбөр боловсруулах
  - Компанийн засаглалыг сайжруулахад шаардлагатай холбогдох тулгамдан асуудлуудаар хэлэлцүүлэг өрнүүлэх, хурал зохион байгуулах
- **Төр, хувийн хэвшлийн оролцоог бэхжүүлэх**
  - Төрийн холбогдох хууль, журам, тогтоол, шийдвэрүүд нь засаглалын зарчимд нийцэж байгаа эсэхэд судалгаа хийж эрх бүхий байгууллагуудад мэргэжил арга зүйгээр хангах
  - Засаглалыг хөгжүүлэх хүрээнд төр - хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бүх шатанд хөгжүүлэх
- **Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах**
  - Хувьцаа эзэмшигч, компанитай холбоотой маргааныг өөрсдийн хүсэлтээр нь хүлээн авч мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх
  - ТУЗ, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийг зарлах, тохиромжтой этгээдийн жагсаалтыг гарган захиалагч байгууллагад хүргүүлэх
  - Холбогдох байгууллага, иргэдийн хүсэлтээр талуудыг эвлрүүлэн зуучлах, цаашид хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах арбитрын шүүхийн үйл ажиллагааг эрхлэн явуулах

Анхаарал тавьсанд баярлалаа  
[Ganbayar@frc.mn](mailto:Ganbayar@frc.mn)